

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
2020 ОНЫ 03 ДУГААР САРЫН 1 ДЭХ ДОЛОО ХОНОГИЙН
АЖЛЫН ТОВЧ МЭДЭЭ**

Нэг. Зарим статистик үзүүлэлтүүд

№	Үзүүлэлтүүд	Тухайн долоо хоног	Жилийн эхнээс өссөн дүн	Өмнөх онтой харьцуулахад
1	Нийт төрөлт	51	469	-70
2	Амьд төрөлт	50	469	-70
3	Амьгүй төрөлт	1	2	0
4	Дутуу төрөлт	0	8	- 8
5	0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	1	15	+3
6	1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	0	2	-2
7	Эхийн ноцтой хүндрэл	0	0	0
8	Төрөлхийн гажиг	0	5	+3
9	Гэрийн төрөлт	0	0	1

Хоёр. Томуу, томуу төст өвчний мэдээ

Аймгийн хэмжээнд амбулаторид суурилсан томуугийн харуулдан тандалтын 18 нэгжүүдэд 9 дүгээр долоо хоногт нийт 2918 хүн үйлчлүүлсний 209 (7.1 %) нь ТТӨ-тэй тохиолдол бүртгэгдсэн байна. Өмнөх 7 хоногтой харьцуулахад 1.7 %- иар өссөн үзүүлэлттэй байна.

Амьсгалын замын цочмог хүнд халдварын шалтгаантай эмнэлэгт хэвтэгсэд нийт хэвтэгсэд (103)- ийн дотор буюу 21.3 %-ийг эзэлж, өмнөх долоо хоногтой харьцуулахад 0.2 %- иар өссөн үзүүлэлттэй байна.

Аймгийн хэмжээнд түргэн тусламжийн 559 дуудлагын 111 (19.8%)-ийг ТТӨ-ий шалтгаантай дуудлага эзэлж байна. Өмнөх долоо хоногтой харьцуулахад 0.4 %- иар буурсан үзүүлэлттэй байна.

Гурав. Нийгмийн эрүүл мэнд

2020 оны 3 дугаар сарын 2-ны өдөр Москва-Улаанбаатар чиглэлийн онгоцоор Франц улсаас ирж, коронавирусийн халдварын онош батлагдсан иргэний 1-р хавьтал болох Англи улсын иргэнтэй Аеромонголиа компанийн Улаанбаатар-Өлгий-Увс чиглэлийн нислэгээр 2020 оны 3 дугаар сарын 5-ны өдөр хамт ирсэн 32 иргэн, мөн шинэ коронавирусийн халдварын өндөр эрсдэлтэй Франц улсад аялаад ирсэн манай аймгийн иргэнтэй Улаанбаатар-Өлгийн чиглэлд 2020 оны 3 дугаар сарын 8-ны өдрийн Хүннү эйр компанийн нислэгээр хамт ирсэн 43 иргэн, нийт 98 иргэний тархвар зүйн судалгааг хийж, эрүүл мэндийн зөвлөгөө өгөв. Судалгаагаар Өлгий сумд 54, Баяннуур сумд 2, Булган сумд 4, Толбо сумд 1, Дэлүүн сумд 2, Улаанхус сумд 4, Ногооннуур сумд 1 иргэн байгааг тус тус тогтоолоо.

Мөн 2020 оны 3 дугаар сарын 5-ны өдрийн онгоцоор Өлгий-Улаангом-Улаанбаатар чиглэлд зорчсон 23 иргэнтэй утсаар холбогдож, мэдээлэл өгөв.

ЭМГ-ын даргын 2020 оны 02 сарын 28-ний А/09 дүгээр тушаалын дагуу Шуурхай хариу арга хэмжээний багийн хуваарь ёсоор 2 дугаар багийн ахлагч Е.Сауле багаа бүрдүүлэн ажилласан. Эмнэл зүйн эмч А.Рая, тархвар судлаач А.Нургүл, лабораторийн эрхлэгч Х.Гулнар, ариутгагч К.Елауган, жолооч Х.Оспанхан нарыг дайчлан ажилласан. Шуурхай хариу арга хэмжээний 2 дугаар багийн ахлагч Е.Сауле шуурхай, багийн гишүүдийн хувийн хамгаалах хэрэгсэл, багаж хэрэгслийн бэлэн байдлыг ханган, багийг нэгдсэн удирдлагаар ханган ажилласан.

ЭМС-ын 2020 оны А/135, А/93 дугаар тушаалын дагуу 2020 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 09 цаг 34 минутанд COVID-19-ийн хавьталын тохиолдлыг АНЭ-ийн тусгаарлах өрөөнд тусгаарлаж, тархвар зүйн тандалт, судалгаа болон, Х.Н гэдэг иргэнээс хамрын арчдас авч явуулсан. 2020 оны 03 дугаар сарын 10-ний өдөр Шуурхай хариу арга хэмжээний 2 багийн ахлагчийн өгсөн үүргийн дагуу ажиглалтад байсан иргэн Н-ийн ар гэрт нь өгөх шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх 4 төрлийн зөвлөмж, 10ш маскийг Раушан Өрхийн ЭМТ-ийн эмчид хүлээлгэж өгч хяналтанд авахуулж, мэдээлэлээр хангасан.

ЗӨСТ-ийн халдваргүйтгэлийн баг нь 3 сарын 10-ний өглөөний 09:40 минутанд очиж, 2020 оны 02 сарын 21-ний өдрийн ЗӨСҮТ-ийн даргын А/15 тушаалын дагуу нийт 2792 м.кв талбайг 0,06%-ийн жавелионы 40 л уусмалаар эцсийн халдваргүйтгэл хийж, иргэний гэрийн нийт 5 кг хогийг зааврын дагуу халдваргүйтгэн устгал хийсэн. Ар гэрийн 6 хүнд Сургалт сурталчилгааны зөвлөмж өгч ажилласан байна.

Ажиглалтаар тусгаарлах байранд хүнээ зөөж ирсэний дараа 2 багийн ариутгагч эцсийн халдваргүйтгэл хийсэн. Эрүүл мэндийн газрын дарга, Аймгийн МХГ-ын байцаагчид, Хэлтсийн дарга нар, мэргэжилтэн орсон бүрэлдхүүнүүдэд тандалтын дүнг танилцуулсан хурал хийсэн.

3 сарын 9-13-ний хооронд радиогоор 5 мэргэжилтэн зөвөлгөө өгсөн ба радиогоор ярилцлага өгөх эмч нарын хуваарь гаргасан.

“Саян TV”-гээр “Хүрээлэн буй орчны хог хаягдал, хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөө” сэдвээр ард иргэдэд зориулсан теле хичээл явуулсан

Давсны мэдээлэл сурталчилгааны Дэлхийн 7 хоног компани ажлыг 2020 оны 03 дугаар сарын 09-ний өдрөөс 15-ны хооронд “Таны худалдан авдаг хүнсэнд хэр зэрэг их давс нуугдаж байгааг мэдэх үү?” уриан дор зохион байгуулж байна.

2020 оны 02 дугаар сарын байдлаар А гепатит өвчний нийт 24 тохиолдол бүртгэгдсэн бөгөөд 2020 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн байдлаар 3 шинэ тохиолдол бүртгэгдснээс Өлгий сум 1, Буянт сум 1, Улаанхус сумд 1 тохиолдол тус тус бүртгэгдэж, ЭМС-ын А/527 тоот тушаалын дагуу А гепатит өвчний шаргүй далд хэлбэрийн үзлэгт 18 хүнийг хамруулж, эцсийн ариутгал, халдваргүйтгэлийг цаг тухайд нь 250 мкв. талбайд хийж, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулж ажилласан. Цаашид Улаанхус, Буянт сумд шинэ тохиолдлын голомт нэмэгдэх хандлагатай байна.

- Буянт сумын ЭМТ-өөс санаачлан А гепатит өвчний ойр хавьтлын 10 дэлгүүр, 2 банк, 4 дүгээр багийн 40 айлын 3200м² талбайд халдваргүйтгэл хийж 56 айлд идэвхитэй тандалт хийж, 50 айлд гар угаах нянгийн эсрэг саван тарааж Гар угаах, гарын эрүүл ахуй, А гепатит өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар зөвлөгөөг айл тус бүрээр өгсөн байна.
- Мөн Буянт сумын захиргааны Байгаль, орчны байцаагчтай хамтран 95 айл, өрхийн хашааны ариун цэвэр, хогийн цэг, ил задгай хог, муу усны цооног болон орчны

эрүүл ахуйд айл тус бүрээр нь хяналт үнэлгээ хийж зөвлөгөө, албан даалгавар өгч зөрчлийг ариулгуулах арга хэмжээг авч ажилласан.

Дербес ТВ-ээр А гепатит, Салхинцэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар ард иргэдэд чиглэсэн зөвлөгөөг теле хичээл бэлдэж танилцуулан сэрэмжүүлэг өгсөн.

Мөн 9 цагийн радиогоор А гепатит, Салхинцэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар ард иргэдэд чиглэсэн сэрэмжлүүлэг өгсөн.

ЭМГ-ЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, МЭДЭЭЛЛИЙН ХЭЛТЭС